

5.2. ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД


Энэхүү хэсэгт Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөц, хүн амын эрүүл мэндийн үйлчилгээ, өвчлөл, нас баралтын ерөнхий төлөв байдлын талаар өгүүлнэ. Монгол улс өргөн уудам нутаг дэвсгэртэй үүнээс үүдэн газар зүйн болон байр зүйн нөхцөл байдал нь хот, хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн байдалд ихээхэн ялгаатай байдлыг үүсгэдэг. Хөдөөгийн хүн ам наад захын эрүүл ахуйн шаардлагыг сахих боломж хязгаарлагдмал, хамгаалалтгүй худаг, уст цэгээс ундны ус авч хэрэглэдэг, байгалийн эрс тэс уур амьсгалд амьдардаг зэрэг нь эрүү мэндэд сөргөөр нөлөөлж байна¹⁴⁵. Нөгөө талаар агаарын бохирдол, хүн амын хэт төвлөрөл, чимээ шуугиан, стресс, зам тээврийн осол гэмтэл зэрэг хотын хүн амд тохиолддог сөрөг үр дагавраас ангид амьдардаг байна. Эдгээрээс хамааран хөдөөгийн хүн амын өвчлөлийн ерөнхий төрх хотын хүн амынхаас ихээхэн ялгаатай болдог. Мөн жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ, ДОХ, бэлгийн замын халдвар авах эрсдэлтэй бүлгийн хүн амын амьдралын хэв маяг, зуршил, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, БЗДХ/ДОХ-ын талаарх мэдлэг, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдах боломжийг судалсан болно.

5.2.1 Эрүүл мэндийн байгууллага, үйлчилгээ


5.2.1.1 Эмнэлгийн хүний нөөц, тусламж үйлчилгээ

Эрүүл мэндийн стандартын доод хэмжээнээс Гурвантэс сумын эмнэлэгт 2, Номгон сумын эмнэлэгт 1 их эмчээр дутуу, Сэврэй, Ханхонгор, Цогт-Овоо сумдад стандартын доод хязгаарт, харин бусад сумдын эмнэлэгт стандартын доод хэмжээнээс 1-2 их эмчээр илүү үйл ажиллагаагаа явуулж байна.

Зураг 5.2.1.1 Сумын болон сум дундын эмнэлгийн их эмчийн хангамж, 2007



Зураг 5.2.1.2 10000 хүн амд ногдох сумын болон сумдын эмнэлгийн их эмчийн тоо, 2005-2007



Эх ноддай а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007


Сумын болон сум дундын эмнэлгийн 10000 хүн амд ногдох их эмчийн тоо сүүлийн 3 жилд тасралтгүй өсч байна (Зураг 5.2.1.3). Гэхдээ сум болгоноор энэ үзүүлэлтийг авч үзэхэд нэлээд ялгаатай дүр зураг харагдаж байна.

¹⁴⁵ Монголын хүний хөгжлийн илтгэл-2003, Улаанбаатар, 2004 он

Аймгийн төвийн өрхийн эмнэлгийн их эмчийн тоо эрүүл мэндийн стандартын доод хэмжээнээс илүү байгаа ба харин аймгийн нэгдсэн эмнэлгийн хувьд 2007 оны байдлаар 37 их эмч ажиллаж байгаа бөгөөд стандарт хангалт 90.9 хувьтай байна.


Өмнөговь аймгийн сумдын эмнэлгийн хувьд сувилагчдын тоо стандартад хүрээгүй, тодруулбал, 2007 оны байдлаар Баяндалай, Баян-Овоо, Булган, Мандал-Овоо, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Ноён сумдад стандартын доод хэмжээнээс 1-3 сувилагчаар дутуу үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн нэгдсэн эмнэлгийн хувьд нарийн мэргэжлийн сувилагч болон эмнэлгийн дунд мэргэжилтэн хангалтгүй, стандарт хангалт дөнгөж 66.9 хувьтай байна.

Зураг 5.2.1.3 Сумдын эмнэлгийн 10000 хүн амд ногдох их эмчийн тоо, 2005-2007



Эх ноддаг а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007


Зураг 5.2.1.4 Сумдын эмнэлгийн 10000 хүн амд ногдох сувилагчийн тоо, 2005-2007



Эх н᠔д᠗᠗᠗: Өмн᠔говь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмн᠔говь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Сумын эмнэлгийн үйл ажиллагааны улсын стандартаар сумын багийн тоогоор бага эмч ажиллах ёстой байдаг. Өмн᠔говь аймгийн сумдын хэмжээгээр багийн бага эмчийн стандарт хангалтгүй, нийтдээ 48 багт төдий хэмжээний бага эмч ажиллах ёстой боловч 2007 оны байдлаар 8 сумын (Баяндалай 1, Баян-Овоо 2, Булган 1, Гурван тэс 2, Мандал-Овоо 1, Манлай 1, Номгон 2, Цогтцэций 1) 10 баг бага эмчгүй, аймгийн хэмжээгээр стандарт хангалт 79.2 хувьтай байна.

Зураг 5.2.1.5 Сумдын эмнэлгийн 10000 хүн амд ногдох багийн бага эмчийн тоо, 2005-2007



Эх нэгдлийг а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын болон хүртээмжийн үндсэн үзүүлэлтүүдэд 10000 хүн амд ногдох ор, дундаж ор хоног, орны фонд ашиглалт, орны эргэлтийн үзүүлэлтүүд багтдаг. 2007 оны байдлаар Өмнөговь аймгийн эмнэлгийн нийт орны 45 хувь сумын болон сум дундын эмнэлэгт ногдож байна.

Аймгийн хэмжээнд дундаж ор хоног 2005 онд 7.3 хоног байсан бол 2007 онд 7.5 болж бага зэрэг өссөн ба харин орны фонд ашиглалт 2007 онд 255.5 болж, 2005 оныхоос 23.2 пунктээр нэмэгдсэн байна. Өмнөговь аймагт улсын эмнэлгээс гадна 4 хувийн эмнэлэг ажилладаг бөгөөд эдгээр эмнэлгийн дундаж ор хоногийн тоо 2007 онд аймгийн дунджаас хоёр хоног, аймгийн нэгдсэн эмнэлгийнхээс даруй 4 орчим хоногоор өндөр байна.

Хүснэгт 5.2.1.1 Өмнөговь аймгийн бүх шатны эмнэлгийн 10000 хүн амд ногдох ор, орны фонд ашиглалт, 2005-2007

Байгууллагаар	10000 хүн амд ногдох ор			Дундаж ор хоног			Орны эргэлт			Орны фонд ашиглалт		
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
БД	38.5	39.2	38.9	7.5	6.4	8.1	37.2	33.9	34.3	278.3	218.1	277.2
БО	58.5	59.2	58.5	6.9	6.6	7.2	25.2	30.4	35.1	173.0	200.9	253.6
БУ	37.0	38.8	38.8	6.3	6.8	6.5	30.0	28.9	34.7	190.3	196.0	226.9
ГТ	28.4	27.3	26.3	6.6	6.9	7.0	35.3	37.4	38.5	232.6	257.6	268.2
МО	44.9	44.8	45.0	8.2	8.0	7.6	29.7	25.9	25.9	242.0	208.2	197.2
МА	37.0	36.4	35.9	7.6	8.1	8.3	34.0	32.6	32.1	259.2	264.2	267.6
НМ	33.2	35.6	32.5	7.3	7.2	7.2	21.9	18.9	20.3	160.2	136.1	147.1
СЭ	39.0	39.9	40.2	7.4	6.7	6.2	32.6	31.9	30.7	242.0	215.1	190.6
ХБ	33.8	31.0	30.4	7.0	6.3	7.1	33.2	37.1	37.8	231.7	234.9	268.2
ХХ	35.4	36.0	35.9	7.5	8.1	7.6	24.9	28.1	28.1	187.2	226.8	213.7
ХҮ	47.1	51.8	52.0	8.3	7.9	8.8	31.3	30.4	35.8	258.7	239.1	315.9
ЦО	53.8	53.7	54.2	7.5	7.3	6.7	29.7	31.4	37.0	221.1	231.0	248.7
ЦЦ	41.8	42.4	41.9	6.8	7.0	6.5	35.9	43.6	45.0	243.4	302.8	290.4
НО	107.9	110.9	115.6	7.4	7.1	7.6	38.9	40.3	36.4	287.7	287.7	247.8
НЭ	-	-	-	7.3	7.4	5.7	29.7	31.8	37.5	216.9	235.8	285.7
ЦЭ	-	-	-	6.7	7.8	6.8	29.9	42.4	15.8	202.9	222.2	110.8
ХЭ	-	-	-	9.8	9.5	9.5	35.6	40.2	43.4	350.2	380.4	414.4
ДҮН	64.2	64.4	63.7	7.3	7.4	7.5	30.4	31.6	34.2	222.3	232.5	255.5

Эх сурвалж: Өмнөговь, ЭМГ, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Хүснэгт 5.2.1.2 Өмнөговь аймгийн бүх шатны эмнэлгийн 1 сард хийсэн нийт болон урьдчилан сэргийлэх үзлэгийн тоо, жилд нэг үйлчлүүлэгчийг үзсэн удаа, 2007

Эрүүл мэндийн байгууллагаар	Нийт үзлэг (1 сард дунджаар)	Урьдчилан сэргийлэх үзлэг (1 сард дунджаар)	Нэг үйлчлүүлэгчийг үзсэн удаа
Баяндалай	707.5	345.0	3.7
Баян-Овоо	480.0	254.4	3.8
Булган	858.1	631.5	4.4
Гурван тэс	890.3	547.6	2.9
Мандал-Овоо	564.5	293.5	3.4
Манлай	1019.8	565.5	5.0
Номгон	715.1	391.8	3.1
Сэврэй	868.7	637.0	4.6
Ханбогд	798.7	444.1	3.3
Ханхонгор	988.8	744.3	4.7
Хүрмэн	834.9	551.9	5.8
Цогт-Овоо	413.1	142.4	3.0
Цогтцэций	704.3	374.3	4.0
Ноён сум дундын	1540.3	1065.2	13.7
Нэгдсэн эмнэлэг	3731.5	1360.8	-
Өрхийн эмнэлгүүд	4935.9	2565.3	3.8
Цэргийн эмнэлэг	950.2	899.8	-
Хувийн эмнэлэг	325.3	1.5	-
НИЙТ ДҮН	21326.5	11815.8	5.4

Эх нөхцөл: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

2007 онд сумдын эмнэлгийн хүрээнд сард дунджаар 455 удаа урьдчилан сэргийлэх үзлэг хийсэн нь 2006 оныхоос 48 үзлэгээр илүү байна. Ер нь урьдчилан сэргийлэх үзлэгийг сумдын эмнэлэг одоогийн ойлголтын хэмжээнд хоорондоо их ялгаатай харилцан адилгүй хэмжээнд хийдэг ажээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгт өдөрт дунджаар 192 хүн үзүүлдэг бөгөөд дотор (25), шүд (24), эмэгтэйчүүдэд (23) хамгийн олон хүн үзүүлдэг байна. Түргэн тусламжийн төвийн дуудлагыг төрлөөр авч үзэхэд 2007 онд нийтдээ 5545 дуудлага авсны 92.9 хувийг гэнэтийн өвчний, 3.0 хувийг осол гэмтлийн, 4.1 хувийг төрөлтийн дуудлага тус тус эзлэж байна. Дээрх хувийн жинг 2005 оныхтой харьцуулахад гэнэтийн өвчний дуудлага 2.8 пунктээр буурсан, осол гэмтэл 1.6, төрөлтийн дуудлага 1.2 пунктээр тус тус өссөн дүн гарчээ. Төрөлтийн дуудлага өссөн шалтгааныг мэргэжлийн хүмүүс “Эхийн эндэгдлийг бууруулах тухай” Эрүүл мэндийн яамны сайдын 2005 оны 190 тоот тушаалын заалтын дагуу жирэмсэн эхчүүд аймгийн төвийн нэгдсэн эмнэлэгт ихээр ирж, төрж байгаатай холбон тайлбарлаж байна.

5.2.1.2 Эхийн эрүүл мэнд

Монгол Улсын эрүүл мэндийн салбарыг 2005-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээнд эх, нялхсын багц тусламж үйлчилгээ нэн тэргүүнд тавигдаж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхдийн эрүүл мэндийн талаар олон чухал арга хэмжээ авч хэрэгжүүлсний дүнд хүүхдийн эндэгдэл тууштай буурсаар байна. Гэвч хөдөөгийн хүүхдийн эрүүл мэнд анхаарал татсан асуудал хэвээр байна. Нийт хүн амын 40 илүүхэн хувийг сумын хүн ам эзэлдэг боловч эх, хүүхдийн эндэгдлийн талаас давсан хувь нь сумын хүн амд ногдож байгаа нь үүний нэг нотолгоо юм.¹⁴⁶

“Эрүүл мэндийн тухай” Монгол Улсын хуульд “эрүүл мэндийн анхан шатны тусламж гэж хүн амд эрүүл мэндийн зайлшгүй болон эмнэлгийн анхны тусламж үзүүлэхэд чиглэгдсэн эрүүл мэндийн анхан шатны байгууллагын үйл ажиллагааг хэлнэ” гэж заасан байдаг тул эх, хүүхдийн эрүүл мэнд гэсэн энэхүү хэсэгт дараах байдлаар харуулахыг зорилоо. Үүнд:

- Жирэмсний болон төрөхийн өмнөх үеийн тусламж үйлчилгээ
- Охидын төрөлт
- Эх, хүүхдийн эндэгдэл
- Хүүхдийн эрүүл мэнд

Жирэмсний болон төрөхийн өмнөх үеийн тусламж, үйлчилгээ Жирэмсэн болон төрөхийн өмнөх эрүүл мэндийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаануудыг хамруулан ойлгодог¹⁴⁷. Үүнд:

- Жирэмснийг эрт илрүүлж, жирэмсний хугацаанд 6 ба түүнээс дээш удаа эмнэлгийн хяналтанд авах;
- Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлээс сэргийлэх, эмчлэх;
- Жирэмсэн эхчүүдийг амин дэм болон бичил элементээр хангах;
- Эхчүүдийн амрах байрны үйлчилгээг сайжруулах.


¹⁴⁶ ЭМЯ, Сумын эрүүл мэндийн хөгжил, 2004, хуудас 13, Улаанбаатар

¹⁴⁷ ЭМЯ, Эрүүл мэндийн үзүүлэлт 2007, 2008, хуудас 11, Улаанбаатар

Жирэмсэн эмэгтэйчүүд жирэмсний эрт үеийн болон байнгын хяналтанд орох нь хавсарсан өвчлөлийг оношлох, эмчлэх улмаар жирэмсний болон төрөх үеийн хүндрэлийг бууруулахад чухал ач холбогдолтой.

Улсын хэмжээнд 2007 онд хөдөө төрсөн эхчүүдийн 86.7 хувь нь жирэмсэн үеийн эрт үеийн хяналтанд орсон бол Өмнөговь аймгийн жирэмсэн эхчүүдийн 82.4 хувь нь эрт хяналтанд хамрагдаж, хамрагдалтын түвшин 2005 оныхоос 0.4 пунктээр буурсан байна. Жирэмсэн эхчүүдийн эрт хяналтын хувь 2007 онд сумдаар харилцан адилгүй, тодруулбал, Мандал-Овоо, Хүрмэн, Цогтцэций, Ханхонгор, Гурвантэс сумдад жирэмсэн эхчүүдийн дөнгөж 66.0-79.4 хувь нь эрт хяналтад орсон хангалтгүй үзүүлэлттэй байна (Зураг 5.2.1.6).

Зураг 5.2.1.6 Жирэмсний эрт хяналтанд хамрагдсан эхчүүдийн хувь, сумаар



Эх нэгдэл: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Зураг 5.2.1.7-д жирэмсний хожуу хяналтанд хамрагдсан эхчүүдийн хувийг сумаар харуулав.

Жирэмсний хожуу хамрагдалтыг сумаар, сүүлийн хоёр жилээр авч үзэхэд Сэврэй, Ханхонгор сумдад жил дараалан өндөр байна.

жигдрүүлэхэд эхийн амрах байрны гол зорилго оршдог. “Эхийн амрах байрны бүтэц үйл ажиллагаа, санхүүжүүлэлтийн журам батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2005 оны 192 тоот тушаал гарснаар эхчүүдийн амрах байранд алслагдсан болон нүүдлийн маягаар амьдарч буй жирэмсэн эхчүүдийн амрах тоо нэмэгдсээр байна.¹⁴⁸

Сумдаар авч үзэхэд сүүлийн 3 жилийн хугацаанд эхийн амрах байраар үйлчлүүлэгчдийн тоо нэмэгдсээр байна. Хэдийгээр нийт дүнгээрээ үзүүлэлтийн тоо нэмэгдэж байгаа боловч сумдын хэмжээнд харилцан адилгүй, жишээ нь өнгөрсөн 2 жилийн хугацаанд Гурвантэс суманд эхийн амрах байр огт ажиллаагүй байна.

Эхчүүдийн амрах байрны дундаж ор хоног 2007 онд 10.3 байна.

Хүснэгт 5.2.1.3 Эхийн амрах байраар үйлчлүүлсэн жирэмсэн эхчүүдийн хувь, сумаар, 2005-2007

Эрүүл мэндийн байгууллагаар	Амрах байраар үйлчлүүлсэн эхийн хувь		
	2005	2006	2007
Баяндалай	78.6	100.0	81.8
Баян-Овоо	90.9	100.0	100.0
Булган	100.0	100.0	100.0
Гурван тэс	-	-	-
Мандал-Овоо	100.0	100.0	100.0
Манлай	54.5	85.7	100.0
Номгон	70.0	100.0	33.3
Сэврэй	100.0	100.0	100.0
Ханбогд	70.6	100.0	100.0
Ханхонгор	100.0	-	100.0
Хүрмэн	100.0	100.0	100.0
Цогт-Овоо	100.0	100.0	100.0
Цогтцэций	100.0	100.0	60.0
Ноён сум дундын эмнэлэг	78.9	98,1	95.9
Нэгдсэн эмнэлэг	100.0	100.0	100.0
НИЙТ ДҮН	78.9	98.1	95.9

Эх нөдөлд: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн хүрээнд 20 хүртлэх насны охидын нийт төрсөн эмэгтэйчүүдэд эзлэх хувийг 2011 он гэхэд 6.0-д хүргэхээр зорилт дэвшүүлсэн.¹⁴⁹ Аймгийн хэмжээнд 2007 онд энэ үзүүлэлт 7.6 хувьтай байгаа нь бараг хөтөлбөрийн суурь он болох 2005 оны улсын хэмжээнд байна гэсэн үг юм. Гэхдээ аймгийн хэмжээнд 2007 оныг 2005 онтой харьцуулахад 3.3 пунктээр буурчээ. Энэ үзүүлэлтийг сумдын хэмжээгээр 2007 оны байдлаар авч үзэхэд аймгийн дунджаас Номгон 2.4, Цогт-Овоо 1.9, Манлай 1.6, Ханбогд 1.4 дахин өндөр байна.

¹⁴⁸ ЭМЯ, Эрүүл мэндийн үзүүлэлт 2007, 2008, хуудас 12, Улаанбаатар

¹⁴⁹ ЭМЯ, Монгол Улсын НҮЭМ үндэсний гурав дахь хөтөлбөр, 2007, хуудас 29, Улаанбаатар

Хүснэгт 5.2.1.4 Өмнөговь аймагт төрсөн эхчүүдийн дунд 20-с доош насны эхчүүдийн эзлэх хувь, сумаар, 2005-2007

Эрүүл мэндийн байгууллагаар	20-оос доош насны эхчүүдийн эзлэх %		
	2005	2006	2007
Баяндалай	9.5	8.8	7.7
Баян-Овоо	10.0	4.5	8.7
Булган	21.3	2.3	8.3
Гурван тэс	14.1	8.7	8.8
Мандал-Овоо	17.9	4.3	3.0
Манлай	15.4	11.1	11.6
Номгон	14.5	11.3	17.2
Сэврэй	17.9	7.5	6.5
Ханбогд	8.2	16.0	10.1
Ханхонгор	13.0	4.8	8.2
Хүрмэн	13.8	9.1	4.0
Цогт-Овоо	10.3	2.8	13.9
Цогтцэций	2.2	11.1	4.1
Ноён сум дундын эмнэлэг	13.8	9.1	4.0
Өрхийн эмнэлгүүд	5.8	4.9	5.4
НИЙТ ДҮН	10.9	7.2	7.6

Эх нөдөг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007


Өмнөговь аймгийн хэмжээнд 10000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдэл 2007 онд 329.3 байгаа нь Баяндалайд 2 эх, Номгонд 1 эх эндсэнээс болжээ. Нялхсын эндэгдэл аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилийн турш буурч, 2005 оныг 2007 онтой харьцуулахад 7.4 пунктээр буурчээ. Гэхдээ эндэгдлийн хэмжээ сумдаар харьцангуй ялгаатай байна. Тухайлбал: өнгөрсөн хугацаанд энэ үзүүлэлт Баяндалай суманд бараг 3 дахин буурсан байхад Булган, Манлай, Цогт-Овоо сумдад 2-3 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 5.2.1.5 Өмнөговь аймгийн 1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл, сумаар, 2005-2007

Эрүүл мэндийн байгууллагаар	1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл		
	2005	2006	2007
Баяндалай	71.4	-	25.6
Баян-Овоо	-	-	-
Булган	21.2	68.1	83.3
Гурван тэс	15.8	28.9	25.0
Мандал-Овоо	35.7	-	-
Манлай	26.3	-	46.5
Номгон	10.1	-	17.2
Сэврэй	35.7	25.0	32.2
Ханбогд	32.7	80.0	-
Ханхонгор	43.4	-	32.7
Хүрмэн	35.7	60.6	40.0
Цогт-Овоо	-	27.8	55.5
Цогтцэций	65.2	83.3	20.4
Ноён сум дундын эмнэлэг	68.9	-	40.0
Өрхийн эмнэлгүүд	26.9	25.1	10.8
НИЙТ ДҮН	29.4	27.7	22.0

Эх нөдөг: Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Зураг 5.2.1.9 Өмнөговь аймгийн 1000 амьд төрөлтөд ногдох перинатал нас баралт, сумаар, 2005-2007



Эх үүсвэр: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007


Өмнөговь аймгийн сумдын перинатал нас баралтыг 2007 оны байдлаар авч үзэхэд 2005 оноос ихэнх сумдад буурсан, гараагүй тохиолдол их байна. Энд анхаарал татсан нэг зүйл бол өмнө нь перинатал нас баралт 2 жил дараалан гарч байгаагүй Баяндалай, Цогтцэций сумдад энэ жил бүртгэгдсэн, 2006 оныхоос 2 суманд нэмж нас баралт гарсан явдал юм. Эндээс сумдын эмнэлгээс үйл ажиллагаа төдийлэн тогтворжиж чадахгүй байна гэж үзэж болохоор байна.

Нялхсын нас баралтын талаар аймгийн нарийн мэргэжлийн эмч нар судалсны үр дүнд дараах дүгнэлтийг өгч байна.

- Нялхсын эндэгдэл жилээс жилд буурах хандлагатай байгаа боловч нярайн эндэгдэл нэмэгдэх хандлагатай байна.
- Жил бүр жирэмсний хордлоготой, бөөрний үрэвсэлтэй эхийн хүүхэд эндэх нь нэмэгдэж, эрүүл эхээс эндсэн нярайн эндэгдэл буурч байна.
- Эндсэн нярайн шалтгаанд дутуу төрөлт, өсөлт хөгжлийн хоцрогдол, гаж хөгжил, ангар үнэлгээний балл бага байгаа шалтгаанууд жил бүр ижил түвшинд, зарим үзүүлэлт нэмэгдэх хандлагатай байгаа нь эхийн аюулгүй илчлэг хоол тэжээл хангалтгүй байна.

- Нярайн халдвараар эндэх тоо жилээс жилд буурч байгаа боловч зохих түвшинд байсаар байгаа нь эхчүүдийн төрөх замын үзвэришлт хангалтгүй, төрөх тасгийн ачаалал хэт их байгаатай холбоотой байна.¹⁵⁰

Зураг 5.2.1.10 Өмнөговь аймгийн 1000 амьд төрөлтөд ногдох 1-5 хүртлэх насны хүүхдийн нас баралт, сумаар, 2005-2007



Эх ноддаг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

2007 онд 1000 амьд төрөлтөд ногдох 1-5 хүртлэх насны хүүхдийн нас баралт Ханбогд, Цогт-Овоо сум, мөн аймгийн төвийн өрхийн эмнэлэгт гарчээ.

5.2.1.3 Хүүхдийн эрүүл мэнд

Энэхүү хэсэгт хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг дархлаажуулалтанд хамрагдсан хүүхдийн тоо, 0-5 насны хүүхдийн суулгалт өвчнөөр өвчилсөн хувийн жин гэсэн үзүүлэлтээр судлав.

Монгол Улсын хэмжээнд хүүхдийн дархлаажуулалт маш үр дүнтэй явагддагийн нэгэн адил Өмнөговь аймаг, сумдын хэмжээнд ч дархлаажуулалтын хувь өндөр байна. 2007 оны байдлаар дархлаажуулалтын хувиар хамгийн бага түвшинд Цогт-Овоо (96.8%), Ханхонгор (96.2%) сумд орж байна (Хүснэгт 5.2.1.6).

¹⁵⁰ Өмнөговь, Онол практикийн бага хурлын илтгэлийн хураангуй, Нярайн эндэгдэлд нөлөөлж буй хүчин зүйлс, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн Р.Тунгалаг, С.Алтанцэцэг, 2007


Хүснэгт 5.2.1.6 Өмнөговь аймгийн хэмжээнд дархлаажуулалтанд хамрагдсан хүүхдийн хувь, дархлаажуулалтын төрөл, сумаар, 2006-2007

Байгуулл агаар	Дархлаажуулалтанд хамрагдалтын хувь											
	2006						2007					
	БЦЖ	САА	5-т вакцин	ВГВ	Улаан бурхан	Дүн	БЦЖ	САА	5-т вакцин	ВГВ	Улаан бурхан	Дүн
БД	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
БО	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
БУ	100.0	95.0	100.0	100.0	96.8	98.3	100.0	97.0	97.0	100.0	100.0	99.4
ГТ	96.0	97.0	100.0	100.0	98.0	98.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
МО	100.0	97.0	92.0	100.0	96.2	97.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
МА	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
НМ	100.0	98.2	98.0	100.0	98.0	98.8	100.0	96.0	96.0	100.0	98.0	98.0
СЭ	100.0	95.2	98.0	100.0	97.0	98.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХБ	100.0	96.7	100.0	100.0	98.2	98.9	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ХХ	98.0	90.0	89.0	100.0	100.0	95.4	100.0	94.0	94.0	100.0	93.0	96.2
ХҮ	100.0	96.0	100.0	100.0	100.0	99.2	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ЦО	100.0	100.0	100.0	100.0	96.7	99.3	100.0	93.0	97.0	100.0	94.0	96.8
ЦЦ	100.0	100.0	100.0	100.0	96.0	99.2	100.0	100.0	98.0	100.0	97.0	99.0
НО	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ӨЭ	100.0	99.5	100.0	100.0	99.7	99.8	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0
ДҮН	99.4	98.3	99.2	100.0	98.0	98.9	100.0	99.5	99.0	100.0	99.0	99.5

Эх нөдөг: Өмнөговь, ЭМГ, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2006, 2007

2007 оны байдлаар суулгалт өвчнөөр өвчилсөн 0-5 хүртлэх насны хүүхдийн тоо Баян-Овоо (27.2%), Ноён сум (29.2%), Цогт-Овоо (30.6%) суманд хамгийн өндөр байна (Зураг 5.2.1.11).

Зураг 5.2.1.11 0-5 насны хүүхдийн суулгалт өвчнөөр өвчилсөн хувь, сумаар, 2005-2007




Эх нөдөг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

5.2.1.4 Хүн амын өвчлөлт

Өмнөговь аймгийн сумдын хүн амын эрүүл мэндтэй холбоотой зарим үзүүлэлт, тухайлбал 1000 хүн амд ногдох хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон архи, тамхи хэрэглэдэг хүний тоог гаргалаа. 1000 хүн ам ногдох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо Гурвантэс (33.1%), Манлай (27.9%) сумдад олон, Баян-овоо суманд хамгийн цөөн байна.


Зураг 5.2.1.12 1000 хүн амд ногдох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо, сумаар, 2007



Эх нэгдлийг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Сумдын хэмжээнд 1000 хүн тутмаас архи, тамхи хэрэглэдэг хүний тоо Цогтцэций, Хүрмэн, Гурвантэс сумдад хамгийн өндөр байна (Зураг 5.2.1.13).

Зураг 5.2.1.13 1000 хүн амд ногдох архи, тамхи хэрэглэдэг хүмүүсийн тоо, сумаар, 2007



Эх нэгдлийг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007


10000 хүн амд бүртгэгдсэн өвчлөлийг 2007 оны байдлаар авч үзвэл Баяндалай, Гурвантэс, Мандал-Овоо, Сэврэй, Хүрмэн, Цогтцэций, Ноён сумдад өвчлөл өндөр хэмжээнд байна. 2005, 2006 онуудтай харьцуулахад 2007 онд бүртгэгдсэн өвчлөл аймгийн хэмжээгээр 21-22 хувиар нэмэгджээ.

Хүснэгт 5.2.1.7 Өмнөговь аймагт бүртгэгдсэн өвчлөл 10000 хүн амд, сумаар, 2005-2007

Эрүүл мэндийн байгууллагаар	Бүртгэгдсэн өвчлөл 10000 хүн амд		
	2005	2006	2007
Баяндалай	5671.5	3562.7	4394.6
Баян-Овоо	2995.5	2776.3	2631.6
Булган	3234.6	1938.8	2873.8
Гурван тэс	1714.0	2136.8	4640.2
Мандал-Овоо	994.5	1454.9	4210.3
Манлай	3274.4	3387.3	3577.5
Номгон	2529.1	1756.3	1250.4
Сэврэй	2369.0	2455.7	4082.4
Ханбогд	1312.5	1072.0	1085.8
Ханхонгор	2981.9	3773.5	3421.4
Хүрмэн	3502.6	2429.5	4951.1
Цогт-Овоо	5012.0	3393.0	2271.9
Цогтцэций	4570.8	4097.1	4691.2
Ноён сум дундын эмнэлэг	3741.0	4671.1	4198.1
Өрхийн эмнэлгүүд	885.1	1036.6	1109.0
Аймгийн дундаж	2990.9	2948.1	3640.0

Эх нэгдэл: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Зураг 5.2.1.14 Өмнөговь аймгийн хэмжээнд халдварт өвчний тархалт, 10000 хүн амд, сумаар, 2005-2007



Эх нэгдэл: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Зураг 5.2.1.14-с харахад сүүлийн жилүүдэд халдварт өвчний тархалт өмнөх онуудынхаас эрс нэмэгдсэн байна. Ялангуяа, өнгөрсөн онд халдварт өвчний тархалт Хүрмэн, Булган, Цогт-Овоо, Ханхонгор сумууд, мөн аймгийн төвийн өрхийн эмнэлгүүдэд өссөн дүнтэй байна. Аймгийн хэмжээний оношлогдсон 10000 хүн амд ногдох амбулаторийн 10 гол өвчлөлийг 2007 оны байдлаар сумдаар Хүснэгт 5.2.1.8-г харуулав.

Хүснэгт 5.2.1.8 Өмнөговь аймгийн хэмжээнд амбулаторийн тэргүүлэх 10 өвчлөлт, 10000 хүн амд, сумаар, 2007

Сумын нэр	Тэргүүлэх 10 өвчин, 10000 хүн амд														
	Амьстгалын тогтолцооны өвчин	Хоол шингээх эрхтний өвчин	Шээс бэлгийн тогтолцооны өвчин	Цусны эргэлтийн өвчин	Бэртэл хордлого ба бусад	Арьс ба халимны өвчин	Халдварт ба зарим шимэгч өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин	Чих ба хөхөнцөрийн өвчин	Нүдний ба түүний дайврын өвчин	Дотоод шүүрэл бодисын солилцоо	Яс, булчингийн тогтолцооны өвчин	Сэтгэцийн ба аягийн эмгэг	Цус, цус бүтээх эрхтний өвчин	Жирэмслэх, төрөх, төрсний дараах
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
Баяндалай	2161.7(1)	544.7(3)	402.1(4)	579.3(2)	73.5(8)	345.9(5)	*	103.8(7)	125.4(6)	60.5(9)	43.2(10)	*	*	*	*
Баян-Овоо	981.2(1)	428.8(2)	324.9(3)	305.4(4)	*	84.5(6)	*	130.0(5)	26.0(8)	*	*	65.0(7)	26.0(8)	26.0(8)	*
Булган	1188.6(1)	366.1(3)	353.1(4)	400.5(2)	51.7(7)	124.9(6)	*	198.1(5)	*	*	51.7(7)	*	*	17.2(9)	25.8(8)
Гурван тэс	1555.0(1)	596.3(3)	554.2(4)	722.4(2)	*	288.9(6)	*	302.1(5)	65.7(9)	52.5(10)	*	112.9(7)	*	89.3(8)	*
Мандал-Овоо	1364.3(1)	734.6(3)	339.8(4)	864.6(2)	*	174.9(5)	*	*	40.0(6)	20.0(7)	40.0(6)	40.0(6)	*	20.0(7)	*
Манлай	1410.4(1)	816.7(2)	510.0(3)	462.2(4)	183.3(6)	187.3(5)	*	95.6(8)	95.6(8)	43.8(9)	*	143.4(7)	*	*	*
Номгон	250.4(1)	214.6(3)	214.6(3)	217.9(2)	19.3(7)	68.3(4)	*	61.8(5)	*	6.5(9)	22.8(8)	48.8(6)	*	*	*
Сэврэй	1059.5(1)	384.4(3)	348.7(4)	603.5(2)	84.9(7)	138.6(6)	*	183.3(5)	*	*	26.8(10)	71.5(8)	*	31.3(9)	*
Ханбогд	256.5(1)	243.0(2)	226.1(3)	145.1(4)	30.4(6)	*	*	33.7(5)	*	*	*	16.9(7)	6.7(9)	10.1(8)	3.4(10)
Ханхонгор	1316.3(1)	558.4(3)	375.0(4)	598.3(2)	*	255.3(5)	*	219.4(6)	31.9(9)	51.9(8)	16.0(10)	135.6(7)	*	*	*
Хүрмэн	1611.8(1)	491.0(4)	612.4(3)	733.7(2)	75.1(9)	242.6(5)	*	225.3(6)	28.9(10)	104.0(8)	144.4(7)	*	*	*	*
Цогт-Овоо	884.5(1)	481.3(2)	294.8(4)	318.9(3)	42.1(8)	78.2(6)	*	114.3(5)	*	*	12.0(9)	72.2(7)	*	12.0(9)	*
Цогтцэций	1569.6(1)	852.4(3)	1020.0(2)	675.4(4)	102.5(8)	349.3(5)	*	228.2(6)	51.2(9)	*	*	135.1(7)	*	*	46.6(10)
Ноён	924.5(2)	1309.7(1)	570.1(3)	400.6(4)	138.7(7)	131.0(8)	*	231.1(5)	*	*	38.5(10)	208.0(6)	*	*	53.9(9)
Даланзадгад	1108.3(1)	854.6(2)	416.4(4)	129.8(9)	719.6(3)	236.6(7)	*	71.2(10)	279.4(6)	309.7(5)	*	142.3(8)	*	*	*
ДҮН	1148.5(1)	641.8(2)	426.5(3)	382.1(4)	278.3(5)	199.8(6)	182.9(7)*	132.6(8)	117.8(9)	115.9(10)	*	*	*	*	*

Эх нөдөг: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

* Халдварт өвчний оношлогоо зөвхөн аймгийн түвшинд гарсан сумуудын хэмжээнд гарах боломжгүй байна.

Тархвар зүйн шилжилтийн улмаас 1990 оноос эхлэн хүн амын өвчлөл эндэгдлийн шалтгааны бүтцэд өөрчлөлт орж, “Дадал зуршил, зан үйлээс хамааралт” нэр авсан цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хорт хавдар, осол гэмтлийн шалтгаант өвчлөл Монгол Улсад давамгайлах болсон¹⁵¹.

Өмнөговь аймагт 2007 оны байдлаар ихэнх сумдад бүртгэгдсэн 10000 хүн амд ногдох амбулаторийн тэргүүлэх 5 өвчнийг авч үзвэл: *нэгдүгээрт*, амьсгалын тогтолцооны өвчин, *хоёрдугаарт*, хоол шингээх эрхтний өвчин, *гуравдугаарт*, шээс бэлгийн тогтолцооны өвчин, *дөрөвдүгээрт*, цусны эргэлтийн өвчин, *тавдугаарт*, бэртэл хордлого орж байна. Гэхдээ сум бүрээр өвчний дэс дараалал харилцан адилгүй байгааг Хүснэгт 5.2.1.9-өөс харагдаж байна.

Хүснэгт 5.2.1.9 Өмнөговь аймгийн хэмжээнд нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд, сумаар, 2007

Сумын нэр	Нас баралтын тэргүүлэх 5 шалтгаан, 10000 хүн амд								
	Цусны эргэлтийн тогтолцооны өвчин	Гадны шалтгаант өвчлөл ба үхэл	Хавдар	Хоол шингээх эрхтэн тогтолцооны өвчин	Мэдрэлийн тогтолцооны өвчин	Амьсгалын тогтолцооны өвчин	Шээс бэлгийн эрхтэн тогтолцооны өвчин	Төрөлхийн гажиг/перинатал нас баралт	Цус бүтээх эрхтний өвчин
	1	2	3	4	5	6	7	8	9
Баяндалай	26.0(1)	21.7(2)	4.3(3)	*	4.3(3)	4.3(3)	4.3(3)	*	*
Баян-Овоо	39.2(1)	26.1(2)	26.1(2)	*	*	*	*	*	*
Булган	21.5(1)	17.2(2)	*	4.3(3)	*	4.3(3)	*	*	*
Гурван тэс	21.4(1)	8.0(3)	16.0(2)	*	2.7(4)	*	2.7(4)	*	*
Мандал-Овоо	34.9(1)	9.8(2)	5.0(3)	*	5.0(3)	4.3(4)	*	*	*
Манлай	12.9(1)	12.9(1)	4.0(3)	8.0(2)	*	*	4.0(3)	*	*
Номгон	10.2(2)	20.4(1)	3.0(4)	6.8(3)	*	*	3.0(4)	*	*
Сэврэй	17.8(1)	15.1(2)	*	*	4.5(3)	*	4.5(3)	4.5(3)	*
Ханбогд	23.9(1)	3.4(4)	6.8(3)	10.2(2)	*	*	6.8(3)	*	*
Ханхонгор	35.9(1)	7.9(2)	4.0(3)	*	*	4.0(3)	*	*	4.0(3)
Хүрмэн	11.6(2)	4.0(4)	23.6(1)	23.6(1)	7.9(3)	*	*	*	*
Цогт-Овоо	24.0(1)	18.0(2)	12.0(3)	*	*	*	*	*	*
Цогтцэций	23.4(1)	9.4(3)	18.7(2)	9.4(3)	*	9.4(3)	*	*	*
Ноён	30.2(1)	15.1(2)	7.5(4)	8.0(3)	4.0(5)	*	*	*	*
Даланзадгад	19.4(1)	7.4(3)	4.7(4)	11.4(2)	*	*	*	3.3(5)	*
ДҮН	21.8(1)	10.9(2)	7.5(3)	7.0(4)	1.9(5)	1.9(5)	*	*	*

Эх н᠔д᠗᠗᠗ а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Өмнөговь аймагт 2007 оны байдлаар ихэнх сумдад бүртгэгдсэн 10000 хүн амд ногдох нас баралтын тэргүүлэх 5 өвчинд: *нэгдүгээрт*, цусны эргэлтийн тогтолцооны өвчин, *хоёрдугаарт*, гадны шалтгаант өвчлөл ба үхэл, *гуравдугаарт*, хавдар, *дөрөвдүгээрт*, хоол шингээх тогтолцооны өвчин, *тавдугаарт*, мэдрэл, амьсгалын тогтолцооны өвчний нас баралт орж байна.

5.2.1.5 Бэлгийн замын халдварт өвчин

Эрүүл мэндийн статистикийн албан ёсны мэдээллийг харахад улсын хэмжээгээр 2007 онд бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ) дорвитой буурахгүй, нийт халдварт өвчний 29.7 хувийг зонхилон тохиолдог бэлгийн замын халдварт өвчин (БЗХӨ) (тэмбүү, заг хүйтэн,

¹⁵¹ ЭМУХТ, Эрүүл мэндийн үзүүлэлт 2007, 2008, хуудас 31, Улаанбаатар

трихомоноз) эзлэж байна. Өмнөговь аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд БЗХӨ-ний бүх төрлөөрөө (тэмбүү 3.6, заг, хүйтэн 0.6, трихомоноз 0.2 пунктээр) нэмэгджээ. Ялангуяа, тэмбүү Хүрмэн сум, аймгийн төвд, заг, хүйтэн Цогтцэций, Ханбогд сум, аймгийн төвд, трихомоноз Баяндалай, Манлай сум, аймгийн төвд бусдаас өндөр байна.

Хүснэгт 5.2.1.10 Өмнөговь аймгийн хэмжээнд зонхилон тохиолддог бэлгийн замын өвчний тархалт, 10000 хүн амд, сумаар, 2005-2007


Эрүүл мэндийн байгууллагаар	Зонхилон тохиолддог БЗХӨ, 10000 хүн амд								
	Тэмбүү			Заг, хүйтэн			Трихомоноз		
	2005	2006	2007	2005	2006	2007	2005	2006	2007
Баяндалай	-	4.4	-	4.2	4.4	-	8.6	-	17.4
Баян-Овоо	-	6.6	-	-	-	-	19.5	6.6	6.6
Булган	-	-	-	-	4.3	-	16.5	4.3	-
Гурван тэс	-	-	2.7	-	-	-	-	2.7	-
Мандал-Овоо	-	-	-	-	-	-	10.0	10.0	5.0
Манлай	-	-	4.0	4.0	-	-	4.1	8.1	16.2
Номгон	-	-	-	-	-	-	10.0	10.7	7.1
Сэврэй	-	-	-	4.2	4.4	-	-	-	4.4
Ханбогд	-	-	-	-	-	3.4	3.8	10.3	3.4
Ханхонгор	-	4.0	8.0	-	4.0	-	15.7	-	8.0
Хүрмэн	-	-	28.8	-	5.8	-	-	5.8	5.8
Цогт-Овоо	-	-	-	-	-	-	-	6.0	6.0
Цогтцэций	-	-	-	-	-	9.4	4.6	4.7	-
Ноён	-	-	-	-	-	-	-	7.4	-
Өрхийн эмнэлгүүд	1.9	2.7	7.2	6.9	3.4	9.2	12.5	13.6	16.5
НИЙТ ДҮН	0.6	1.5	4.2	3.2	2.4	3.8	9.1	8.0	9.3

Эх нэгдэл: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

5.2.1.6 Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ

Аймгийн хэмжээгээр жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээг төрлөөр авч үзвэл, 28.3 хувь нь эм, 23.7 хувь нь ерөндөг, 21.2 хувь нь тариа, 18.3 хувь нь бэлгэвч хэрэглэж байна (Зураг 5.2.1.15).

Зураг 5.2.1.15 Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэглээний бүтэц, хувиар, 2007



Эх ноддодой а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Аймгийн хэмжээгээр жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээ 2007 онд 2006 оноос 6.1 хувь буурчээ. Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээний хувь 2007 онд Баян-Овоо, Ноён сумдад өндөр байгаа бол аймгийн төвийн өрхийн эмнэлгүүдэд хамгийн бага хувьтай байна (Хүснэгт 5.2.1.11).


Хүснэгт 5.2.1.11 Өмнөговь аймгийн 15-49 насны эмэгтэйчүүдийн жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийн хэрэглээний хувь, сумаар, 2006-2007

Эрүүл мэндийн байгууллагаар	ЖСАХ-ийн хэрэглээний хувь	
	2006	2007
Баяндалай	58.3	55.5
Баян-Овоо	66.0	64.5
Булган	48.3	50.7
Гурван тэс	57.0	58.0
Мандал-Овоо	42.3	45.5
Манлай	46.8	44.7
Номгон	55.2	56.0
Сэврэй	48.3	49.0
Ханбогд	59.5	54.9
Ханхонгор	47.2	44.6
Хүрмэн	57.0	57.9
Цогт-Овоо	47.2	46.1
Цогтцэций	54.7	54.7
Ноён сум дундын эмнэлэг	69.8	70.8
Өрхийн эмнэлгүүд	36.3	37.3
НИЙТ ДҮН	47.5	41.4

Эх ноддодой а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөөг 2007 онд аймгийн хэмжээний 15-49 насны нийт 3208 эмэгтэйд өгсөн ба тухайн суман дахь 15-49 насны эмэгтэйчүүдийн хэдэн хувьд нь өгсөн бэ гэдгийг тооцож үзвэл, Ноён, Баяндалай, Цогтцэций, Гурвантэс, Манлай сумдын хувь хамгийн өндөр байна.

Зураг 5.2.1.16 Гэр бүл төлөвлөлтийн талаар зөвлөгөө авсан эмэгтэйчүүдийн хувь, сумаар, 2007



Эх нийгэмд а: Өмнөговь аймгийн Эрүүл Мэндийн Газар, Өмнөговь аймгийн эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2005-2007

5.2.2 БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлт бүлгийн хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэнд, амьдралын хэв маяг

Тайлангийн энэхүү хэсэгт БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэл өндөр бүлгийн хүн амын амьдралын хэв маяг, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл, түүний талаарх ойлголт, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг, эрсдэлт бүлгийн хүн амын бэлгийн зан үйл, бэлгэвчний хэрэглээ зэргийг тодорхойлохыг зорилоо.

Энэхүү зорилгын хүрээнд 2008 оны 6 сард Өмнөговь аймгийн бүх сумдыг хамруулан зорилтот түүврийн аргаар эрсдэлт бүлгийн 85 хүнийг сонгон, санал асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан болно.

Судалгаанд БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлт бүлэг (цаашид зорилтод бүлэг гэж нэрлэнэ) гэдэгт бэлгийн замаар халдварлах өвчин тусах магадлал бүхий орчинд амьдарч, ажилладаг хүмүүс, тодруулбал, том оврын ачааны тэргийн жолооч, зочид буудал, баар, саунд ажиллагсад болон тэдгээрээр үйлчлүүлэгчид, албан бусаар алт, жонш олборлогчдыг хамруулсан болно.

5.2.2.1 Судалгаанд хамрагдагсдын шинж байдал ба зуршил

Судалгаанд зорилтот бүлгийн нийт 85 хүн хамрагдсанаас 52.9 хувь эмэгтэйчүүд, 47.1 хувь эрэгтэйчүүд байв. Насны хувьд 20-39 насныхан нийт судалгаанд хамрагдагсдын дийлэнх буюу 83.5 хувийг эзэлж байгаа бөгөөд тэдгээрийн насны дундаж 28.4 (max=48, min=19, Std.Dev=7) байлаа. Өөрөөр хэлбэл, судалгаанд харьцангуй залуу, нөхөн үржихүйн идэвхтэй насныхан түлхүү хамрагдсан байна.

Зорилтот бүлгийнхний 47.1 хувийг огт гэрлээгүй хүмүүс, 37.6 хувийг гэрлэсэн буюу хамтран амьдрагчид эзэлж байна. Түүнчлэн судалгаанд хамрагдагсдын 5.9 хувийг бага буюу боловсролгүй, 36.5 хувийг нь бүрэн бус дунд, 40.0 хувийг нь бүрэн дунд, 17.6 хувийг тусгай мэргэжлийн дунд/дээд боловсролтой хүмүүс эзэлж байв.

Ажил эрхлэлтийн байдлыг авч үзвэл, 20.0 хувь нь жолооч, 22.4 хувь нь зочид буудал, бааранд ажиллагсад, 16.5 хувь нь албан бусаар алт олборлогчид, 7.1 хувь нь саунд ажиллагсад, 12.9 хувь нь баар, цэнгээний газраар үйлчлүүлэгчид, 21.2 хувь нь бусад хүмүүс байлаа.

Зорилтод бүлгийн хүн амын бэлгийн эрсдэлтэй зан үйлд тэдний тамхи, архи, согтруулах ундаа болон мансууруулах бодисын хэрэглээ ихээхэн нөлөөтэй байдаг учраас бид судалгаагаараа юуны өмнө энэ талын мэдээллийг цуглуулахыг зорьсон юм. Үр дүнг бүснэгт 5.2.2.1-д харуулав.

Хүснэгтээс харахад судалгаанд хамрагдагсдын 41.2 хувь нь тамхи татдаг, 54.1 хувь нь архи, согтрууруулах ундаа хэрэглэдэг, 1.2 хувь нь мансууруулах бодис хэрэглэдэг юм байна. Насны бүлгээр авч үзвэл, 30-аас дээш насныхан, эрэгтэйчүүд, гэр бүлтэй, боловсролгүй, бага боловсролтой, албан бусаар алт, жонш олборлож байгаа хүмүүсийн тамхины хэрэглээ бусдаас өндөр байна. Харин архи, согтрууруулах ундааг 20-29 насныхан, эрэгтэйчүүд, гэрлээгүй буюу хамтран амьдрагчид, байгалийн ашигт малтмал хувиараа олборлогчид, боловсрол багатай хүмүүс, баар, цэнгээний газраар үйлчлүүлэгч нар түлхүү

хэрэглэдэг нь харагдаж байна. Энд анхаарал татсан нэг асуудал бол судалгаанд хамрагдсан нэг жолооч мансууруулах бодис хэрэглэж байсан явдал юм.

Хүснэгт 5.2.2.1 Судалгаанд хамрагдсан тамхи, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэдэг хүмүүсийн хувь, сонгосон үзүүлэлтээр


Сонгосон үзүүлэлтүүд	Тамхи, архи, хэрэглэдэг хүний хувь			Судалгаанд хамрагдсан хүний тоо
	Тамхи	Архи, согтууруулах ундаа	Мансууруулах бодис	
<i>Нас</i>				
20 хүртэл	12.5	50.0	0.0	8
20-29	38.6	68.2	2.3	44
30-39	51.9	37.0	0.0	27
40 ба дээш	50.0	33.3	0.0	6
<i>Хүйс</i>				
Эрэгтэй	72.5	72.5	2.5	40
Эмэгтэй	13.3	37.8	0.0	45
<i>Гэрлэлтийн байдал</i>				
Огт гэрлээгүй	37.5	60.0	0.0	40
Гэрлэсэн	50.0	42.3	3.8	26
Хамтран амьдардаг	33.3	66.7	0.0	6
Салсан/тусгаарласан/бэл.	38.5	53.8	0.0	13
<i>Боловсролын түвшин</i>				
Боловсролгүй/бага	80.0	80.0	0.0	5
Бүрэн бус	58.1	54.8	0.0	31
Бүрэн дунд	26.5	52.9	0.0	34
ТМД/дээд	26.7	46.7	6.7	15
<i>Ажил эрхлэлт</i>				
Том оврийн тэрэгний Жолооч	52.9	52.9	5.9	17
Зочид буудал, бааранд ажиллагчид	15.8	36.8	0.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	64.3	78.6	0.0	14
Саунд ажиллагсад	33.3	16.7	0.0	6
Баар, цэнгээний газраар үйлчлүүлэгчид	54.5	81.8	0.0	11
Бусад	33.3	50.0	0.0	18
Дүн	41.2	54.1	1.2	85

5.2.2.2 Ажлын байран дахь эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдал ба энэ талаарх мэдлэг

Зорилтот бүлгийнхнээс тэдний ажлын байран дахь эрүүл ахуйн нөхцөл, аюулгүй байдал, түүнчлэн эрүүл ахуйн нөхцлийн талаар тавигддаг шаардлага, дагаж мөрддөг эсэх талаар багц асуултыг оруулсан болно.

Ажлын байрны эрүүл ахуйн орчин, нөхцөл хангагдсан байна гэдэг нь тоосжилт бага (50.6%), ариун цэвэр усны асуудал шийдвэрлэгдсэн (47.1%), агааржуулалттай (41.2%) явдал гэж судалгаанд хамрагдсан зорилтод бүлгийн хүн амын 40-өөс илүү хувь хариулжээ (Зураг 5.2.2.1). Мөн хэт халуун, хэт хүйтэнд ажилахгүй байх явдал ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийн нэг чухал үзүүлэлт мөн гэж тэдний гуравны нэг нь тодорхойлсон байна.

Зураг 5.2.2.1 Судалгаанд хамрагдсан зорилгод бүлгийн хүн амын хувь, ажлын байрны эрүүл, ахуйн орчин нөхцөл хангагдах нөхцлийг тодорхойлсон байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувьтай тэнцэхгүй.

Хүснэгт 5.2.2.2-оос харахад судалгаанд хамрагдагсдын гуравны нэг нь ажлын байран дахь эрүүл мэндийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн нөхцлийн талаар тавигддаг шаардлагын талаар тодорхой мэдлэгтэй, дагаж мөрддөг гэсэн бол дөрөвний нэг нь мэддэг боловч дагаж мөрддөггүй, мөн энэ тооны хүн мэддэггүй, 15 гаруй хувь нь энэ талаар нэг их санаа зовдоггүй ажээ. Энд онцолж тэмдэглэхэд, нас ахих тусам, мөн боловсролын түвшин нэмэгдэх тутам тэдний ажлын байран дахь эрүүл мэндийн аюулгүй байдал ба эрүүл ахуйн нөхцлийн талаар тавигддаг шаардлагын талаар тодорхой мэдлэгтэй, дагаж мөрддөг гэсэн хувь нэмэгдэж байна.

Хүснэгт 5.2.2.2 Судалгаанд хамрагдагсдын ажлын байран дахь эрүүл мэнд, аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл шаардлагын талаарх мэдлэгийн хувь, сонгосон үзүүлэлтээр

Сонгосон үзүүлэлтүүд	Мэддэг эсэх				Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	<i>Мэднэ, дагаж мөрддөг</i>	<i>Мэднэ, дагаж мөрддөггүй</i>	<i>Мэдэхгүй</i>	<i>Санаа зовдоггүй</i>		
<i>Нас</i>						
20 хүртэл	37.5	25.0	12.5	25.0	100.0	8
20-29	43.2	22.7	22.7	11.4	100.0	44
30-39	25.9	29.6	22.2	22.2	100.0	27
40 ба дээш	50.0	0.0	50.0	0.0	100.0	6
<i>Хүйс</i>						
Эрэгтэй	30.0	20.0	37.5	12.5	100.0	40
Эмэгтэй	44.4	26.7	11.1	17.8	100.0	45
<i>Боловсролын түвшин</i>						
Боловсролгүй/бага	20.0	0.0	60.0	20.0	100.0	5
Бүрэн бус дунд	29.0	29.0	29.0	12.9	100.0	31
Бүрэн дунд	38.2	26.5	14.7	20.6	100.0	34
ТМДС/дээд	60.0	13.3	20.0	6.7	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>						
Том оврийн тэрэгний Жолооч	41.2	17.6	29.4	11.8	100.0	17
Зочид буудал, бааранд Ажиллагчид	31.6	31.6	10.5	26.3	100.0	19
Хувиараа алт, жонш Олборлогч	7.1	42.9	42.9	7.1	100.0	14
Саунд ажиллагсад	33.3	33.3	16.7	16.7	100.0	6
Баар, цэнгээний газраар Үйлчлүүлэгчид	36.4	9.1	45.5	9.1	100.0	11
Бусад	66.7	11.1	5.6	16.7	100.0	18
Дүн	37.6	23.5	23.5	15.3	100.0	85

Судалгаанд хамрагдагсад ажлын байрныхаа эрүүл ахуйн нөхцөлд үнэлгээ хийсэн байдлыг авч үзэхэд, бараг тал орчим хувийнхны ажлын байр тоосжилт ихтэй, өрөөний багтаамж муутай, дуу чимээ ихтэй байдаг байна. Ерөнхийд нь дүгнэхэд ажлын байрны нөхцөл хангалтгүй байна гэж хэлж болно (Хүснэгт 5.2.2.3).

Хүснэгт 5.2.2.3 Судалгаанд хамрагдсдын ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийн үнэлгээний хувь, ажлын байрны нөхцлөөр

Ажлын байрны нөхцөл	Ажлын байрны нөхцлийн үнэлгээ			Бүгд
	<i>Сайн</i>	<i>Дунд</i>	<i>Муу</i>	
Тоосжилт	27.1	27.1	45.9	100.0
Ариун цэвэр	38.8	36.5	24.7	100.0
Ундны ус	49.4	30.6	20.0	100.0
Агааржуулалт	27.1	43.5	29.4	100.0
Өрөөний багтаамж	24.7	31.8	43.5	100.0
Хэт халуун/хэт хүйтэн	20.0	51.8	28.2	100.0
Хэт чийглэг/ хэт хуурай	17.6	45.9	36.5	100.0
Дуу чимээ	18.8	31.8	49.4	100.0
Ажлын хувцас, хэрэгсэл, багаж	32.9	31.8	35.3	100.0

5.2.2.3 БЗДХ/ДОХ-ын талаарх мэдлэг ба бэлгийн амьдрал

Бэлгэвчтэй бэлгийн хавьталд орохыг хүсээгүй жирэмслэлт, бэлгийн замаар дамжих халдвар, ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх аюулгүй бэлгийн хавьтал гэж судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн хүн амын дийлэнх буюу 82.4 хувь нь тодорхойлсон байна (Зураг 5.2.2.2). Мөн тэдгээрийн 44.7 хувь нь олон хавьтагчгүй байх, 16.5 хувь нь тохиолдлын бэлгийн хавьтлаас татгалзах явдал аюулгүй бэлгийн хавьтлын нэг гол хэмжүүр гэжээ.

Зураг 5.2.2.2 Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн хүн амын хувь, аюулгүй бэлгийн хавьтлыг тодорхойлсон байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувиас илүү.

Судалгаанд хамрагдагсдын дийлэнх нь бэлгийн замаар дамжих халдваруудаас ДОХ (95.3%), тэмбүү (83.5%), заг хүйтэн (74.1%) өвчнийг мэднэ гэсэн байна. Үндэсний хэмжээнд халдварт өвчний тархалт өндөр байгаа мөөгөнцөр, трихомониаз өвчний талаар тэдгээрийн тал орчим хувь мэдэх ажээ (Зураг 5.2.2.3).

Зураг 5.2.2.3 Судалгаанд хамрагдсан зорилгод бүлгийн хүн амын хувь, БЗДХ-


уудыг нэрлэсэн байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувиас илүү.

Судалгаанд хамрагдсан БЗДХ/ХДХВ/ДОХ-ийн халдвар авах эрсдэл өндөр бүхий бүлгийн хүн ам БЗДХ авсан хүнд илрэх шинж тэмдгүүдийг хэрхэн тодорхойлсон байдлыг Зураг 5.2.2.4-д харуулав.

Зураг 5.2.2.4 Судалгаанд хамрагдсан зорилгод бүлгийн хүн амын хувь, БЗДХ авсан хүнд илрэх шинж тэмдгийг тодорхойлсон байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувьтай тэнцэхгүй.


Бэлэг эрхтэн дээр юм гарах (41.2%), үтрээ/бэлэг эрхтний орчим өвдөх (38.8%), шээхэд өвдөж, хүндрүүлэх (34.1%) зэргээр өвчний шинж тэмдгүүд илэрнэ гэж судалгаанд хамрагдагсдын гуравны нэгээс илүү хувь нь хариулжээ. Харамсалтай нь, БЗДХ авсан хүнд

илрэх шинж тэмдгүүдийн талаар мэдэхгүй гэж 31.8 хувь нь хариулсан бөгөөд хэрвээ тэд халдвар авбал өвчнийг хүндрүүлэх, бусдад халдаах өндөр эрсдлийг дагуулж байна.

Судалгаагаараа бид зорилтод бүлгийн хүн амын ХДХВ/ДОХ-ын талаарх мэдлэг хэр бодитой байна вэ гэдгийг тандах зорилгоор ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй хүн амыг тэднээр тодорхойлуулсан бөгөөд үр дүнг Зураг 5.2.2.5-д харууллаа.

ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй хүн амыг тэдний 76.5 хувь нь биеэ үнэлэгчид, 47.1 хувь нь олон бэлгийн хавьтагчтай хүмүүс гэж тодорхойлсон нь харьцангуй хамгийн өндөр хувийг эзэлж байна. Түүнчлэн тэдний гуравны нэгээс илүү хувь нь тохиолдлын бэлгийн хавьталд ордог, ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй гэж хариулжээ. Насанд хүрсэн хүн амын хувьд төдийгүй бэлгийн зан үйл, дадлын хувьд бэлгийн замын халдварт өвчнөөр өвчлөх эрсдэл өндөр бүлгийн хүн амын хувьд судалгааны зорилтод бүлгийнхэн ХДХВ/ДОХ-ын халдварт эрсдэлтэй хүн амыг тодорхойлсон байдал хангалтгүй байна. Тодруулбал, тэд зөвхөн бэлгийн зан үйлтэй холбоотойгоор ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй хүмүүсийг дурьджээ. Гэтэл бэлгийн замаас гадна ХДХВ/ДОХ-ын халдвар бүхий жирэмсэн эхээс төрж буй хүүхэд, шивээс хийлгэгчид, зүү тариур хэрэглэдэг өвчлөмтгий хүмүүс дээрх эрсдэлд өртөх өндөр магадлалтай хүмүүс юм. Харамсалтай нь эдгээр эрсдэлтэй хүн амын талаар судалгаанд хамрагдагсдын ердөө арван хүн тутмын нэг л дурьджээ.

Зураг 5.2.2.5 Судалгаанд хамрагдсан зорилтод бүлгийн хүн амын хувь, ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй хүн амыг тодорхойлсон байдлаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувьтай тэнцэхгүй.

БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэхийн тулд судалгаанд хамрагдсан таван хүн тутмын дөрөв нь бэлгэвч хэрэглэх хэрэгтэй гэжээ. Харин тавны хоёр хүрэхгүй хувь нь бэлгийн хосдоо үнэнч байх (38.8%), ариутгаагүй зүү, тариур хэрэглэхээс зайлсхийх (37.6%) хэрэгтэй гэсэн байна (Зураг 5.2.2.6)

Зураг 5.2.2.6 Судалгаанд хамрагдсан зорилгод бүлгийн хүн амын хувь, ХДХВ/ДОХ-оос сэргийлэх арга замыг тодорхойлсон байдлаар




Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувьтай тэнцэхгүй.

Судалгаанд хамрагдсан зорилгот бүлгийн хүн амын 94.1 хувь (N=82) нь бэлгийн хавьталд орсон хүмүүс байв. Эдгээр хүмүүсийн 3.7 хувь нь бэлгийн хавьталд орсон боловч бэлгэвч огт хэрэглэж үзээгүй гэжээ (Зураг 5.2.2.7).

Бэлгийн хавьталд орсон хүмүүсийн дийлэнх буюу 85.4 хувь нь БЗДХ/ХДХВ/ДОХ-оос сэргийлэх (42.7%), тохиолдлын бэлгийн хавьталд орохдоо (42.7%) бэлгэвч хэрэглэж байсан гэжээ.

Зураг 5.2.2.7 Судалгаанд хамрагдсан зорилгод бүлгийн хүн амын хувь, бэлгэвчийн хэрэглээ шалтгаанаар



Тайлбар: Олон сонголттой хариулт тул нийлбэр дүн 100 хувиас илүү.

Хүснэгт 5.2.2.4-д судалгаанд хамрагдагсдын ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй эсэх талаар тэд өөрсдийгөө хэрхэн үнэлснийг харуулав.

Зорилтот бүлгийнхний 21.2 хувь нь ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй, 63.5 хувь нь эрсдэлгүй гэсэн бол 15.3 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг өгчээ. Эрсдэлтэй гэсэн хариултыг эрэгтэйчүүд, хамтран амьдрагч нар, боловсролгүй/бага боловсролтой, жолооч, саунд ажиллагсад илүү түлхүү өгсөн бол албан бусаар алт, жонш олборлогчдын “Үгүй”, “Мэдэхгүй” гэсэн хариулт бусдаас өндөр байна.

Хүснэгт 5.2.2.4 Судалгаанд хамрагдагсад өөрсдийгөө ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлтэй эсэхээ дүгнэсэн байдал, сонгосон үзүүлэлт, хувь

Сонгосон үзүүлэлтүүд	ХДХВ/ДОХ-ын эрсдэлтэй эсэх			Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	Эрсдэлтэй	Эрсдэлгүй	Мэдэхгүй		
<i>Нас</i>					
20 хүртэл	25.0	75.0	0.0	100.0	8
20-29	20.5	65.9	13.6	100.0	44
30-39	25.9	51.9	22.2	100.0	27
40 ба дээш	0.0	83.3	16.7	100.0	6
<i>Хүйс</i>					
Эрэгтэй	25.0	57.5	17.5	100.0	40
Эмэгтэй	17.8	68.9	13.3	100.0	45
<i>Гэрлэлтийн байдал</i>					
Огт гэрлээгүй	22.5	72.5	5.0	100.0	40
Гэрлэсэн	15.4	61.5	23.1	100.0	26
Хамтран амьдардаг	33.3	33.3	33.3	100.0	6
Салсан/тусгаарласан/бэлбэсэн.	23.1	53.8	23.1	100.0	13
<i>Боловсролын түвшин</i>					
Боловсролгүй/бага	40.0	60.0	0.0	100.0	5
Бүрэн бус дунд	12.9	64.5	22.6	100.0	31
Бүрэн дунд	23.5	58.8	17.6	100.0	34
ТМД/дээд	26.7	73.3	0.0	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>					
Том оврийн тэрэгний жолооч	35.3	58.8	5.9	100.0	17
Зочид буудал, бааранд ажиллагчид	15.8	73.7	10.5	100.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	14.3	42.9	42.9	100.0	14
Саунд ажиллагсад	33.3	50.0	16.7	100.0	6
Баар, цэнгээний газраар үйлчлүүлэгчид	18.2	81.8	0.0	100.0	11
Бусад	16.7	66.7	16.7	100.0	18
Дүн	21.2	63.5	15.3	100.0	85

Хүснэгт 5.2.2.5-аас харахад судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийнхний 85.9 хувь нь тохиолдлын бэлгийн харьцаанд ордог, үүнээс 10.6 хувь нь байнга тохиолдлын бэлгийн харьцаанд ордог юм байна. Ялангуяа эрэгтэйчүүд, хамтран амьдрагч нар болон огт боловсролгүй, бага боловсролтой хүмүүс тохиолдлын бэлгийн харьцаанд орох нь олонтой байдаг байна. Эндээс судалгаанд хамруулсан зорилтот бүлгийнхэн тохиолдлын бэлгийн хавьталд ордог, БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах ихээхэн эрсдэлтэй болох нь харагдаж байна.

Түүнчлэн судалгаанд хамрагдсан гурван хүн тутмын нэг нь ХДХВ/ДОХ-ын шинжилгээ өгсөн гэсэн хариултыг өгчээ. Ялангуяа шинжилгээ өгсөн гэж саунд ажиллагсад (50.0%), жолооч нар (41.2%), эмэгтэйчүүд (40.0%) бусдаас илүү хариулжээ.

Хүснэгт 5.2.2.5 Судалгаанд хамрагдагсад тохиолдлын бэлгийн харьцаанд орсон эсэх, сонгосон үзүүлэлт, хувь

Сонгосон үзүүлэлтүүд	Тохиолдлын бэлгийн харьцаанд ордог эсэх			Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	<i>Огт үгүй</i>	<i>Хааяа нэг ордог</i>	<i>Ер нь ордог</i>		
<i>Нас</i>					
20 хүртэл	25.0	75.0	0.0	100.0	8
20-29	15.9	72.7	11.4	100.0	44
30-39	11.1	74.1	14.8	100.0	27
40 ба дээш	0.0	100.0	0.0	100.0	6
<i>Хүйс</i>					
Эрэгтэй	5.0	75.0	20.0	100.0	40
Эмэгтэй	22.2	75.6	2.2	100.0	45
<i>Гэрлэлтийн байдал</i>					
Огт гэрлээгүй	20.0	72.5	7.5	100.0	40
Гэрлэсэн	15.4	76.9	7.7	100.0	26
Хамтран амьдардаг	0.0	66.7	33.3	100.0	6
Салсан/тусгаарласан/бэлбэсэн.	0.0	84.6	15.4	100.0	13
<i>Боловсролын түвшин</i>					
Боловсролгүй/бага	0.0	60.0	40.0	100.0	5
Бүрэн бус дунд	9.7	77.4	12.9	100.0	31
Бүрэн дунд	11.8	79.4	8.8	100.0	34
ТМД/дээд	33.3	66.7	0.0	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>					
Том оврийн тэрэгний жолооч	11.8	70.6	17.6	100.0	17
Зочид буудал, бааранд ажиллагчид	15.8	73.7	10.5	100.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	0.0	85.7	14.3	100.0	14
Саунд ажиллагсад	16.7	83.3	0.0	100.0	6
Баар, цэнгээний газраар үйл- лэгчид	18.2	72.7	9.1	100.0	11
Бусад	22.2	72.2	5.6	100.0	18
Дүн	14.1	75.3	10.6	100.0	85

5.2.2.4 Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж ба өвчлөлт

Эрүүл мэндийн үйлчилгээнээс хүртэх боломжийг харуулсан нэг үзүүлэлт бол иргэдийн даатгалд хамрагдалт билээ. Судалгаанд хамрагдагсдын талаас илүү хувь нь эрүүл мэндийн даатгалтай бөгөөд тэд өнгөрсөн сард хураамжаа төлжээ. Гэтэл судалгаанд хамрагдсан дөрвөн хүн тутмын нэг нь даатгалгүй, ялангуяа салсан/тусгаарласан/бэлбэсэн хүмүүсийн тал орчим хувь, саунд ажилладаг, баар цэнгээний газраар үйлчлүүлдэг гурван хүн тутмын нэг нь эрүүл мэндийн даатгалгүй байна (Хүснэгт 5.2.2.6).

Хүснэгт 5.2.2.6 Судалгаанд хамрагдагсад эрүүл мэндийн даатгалтай эсэх, сонгосон үзүүлэлт, хувь

Сонгосон үзүүлэлтүүд	Эрүүл мэндийн даатгалтай эсэх			Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	Даатгалтай, өнгөрсөн сарын хураамжаа төлсөн	Даатгалтай, өнгөрсөн сарын хураамжаа төлөөгүй	Даатгалгүй		
<i>Нас</i>					
20 хүртэл	37.5	37.5	25.0	100.0	8
20-29	59.1	22.7	18.2	100.0	44
30-39	44.4	29.6	25.9	100.0	27
40 ба дээш	50.0	33.3	16.7	100.0	6
<i>Хүйс</i>					
Эрэгтэй	47.5	30.0	22.5	100.0	40
Эмэгтэй	55.6	24.4	20.0	100.0	45
<i>Гэрлэлтийн байдал</i>					
Огт гэрлээгүй	55.0	17.5	27.5	100.0	40
Гэрлэсэн	57.7	38.5	3.8	100.0	26
Хамтран амьдардаг	50.0	50.0	0.0	100.0	6
Салсан/тусгаарласан/бэлбэсэн.	30.8	23.1	46.2	100.0	13
<i>Боловсролын түвшин</i>					
Боловсролгүй/бага	20.0	60.0	20.0	100.0	5
Бүрэн бус дунд	32.3	35.5	32.3	100.0	31
Бүрэн дунд	58.8	26.5	14.7	100.0	34
ТМД/дээд	86.7	0.0	13.3	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>					
Том оврийн тэрэгний жолооч	82.4	11.8	5.9	100.0	17
Зочид буудал, бааранд ажилчид	52.6	26.3	21.1	100.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	7.1	64.3	28.6	100.0	14
Саунд ажиллагсад	50.0	16.7	33.3	100.0	6
Баар, цэнгээний газраар үйлчлүүлэгч	54.5	9.1	36.4	100.0	11
Бусад	55.6	27.8	16.7	100.0	18
Дүн	51.8	27.1	21.2	100.0	85

Энд онцолж тэмдэглэхэд, жолооч нарын эрүүл мэндийн даатгалд хамрагдалтын хувь бусдаас өндөр буюу 82.4 хувьтай байна.

Хүснэгт 5.2.2.7-д судалгаанд хамрагдагсдын эрүүл мэндийн үйлчилгээ зөвлөгөө ихэвчлэн авдаг эмнэлгийн төрлийг дэлгэрэнгүй харуулав.

Зорилтот бүлгийнхний талаас илүү хувь нь сумын эмнэлэгт үзүүлдэг юм байна. Энэ нь судалгаа Өмнөговь аймгийн хөдөөгийн сумдын хэмжээнд түлхүү хийсэнтэй холбоотой. Гэхдээ хүснэгтээс харахад техник мэргэжлийн дунд/дээд боловсролтой хүмүүс, мөн жолооч нарын улсын эмнэлгээс эрүүл мэндийн үйлчилгээ, зөвлөгөө авдаг хувь өндөр байна.

Хүснэгт 5.2.2.7 Судалгаанд хамрагдагсадын эрүүл мэндийн үйлчилгээ зөвөлгөө авдаг эмнэлгийн төрөл, сонгосон үзүүлэлт, хувь

Сонгосон үзүүлэлтүүд	Эрүүл мэндийн байгууллага						Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	Улсын нэгдсэн эмнэлэг /хот	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Сумын эмнэлэг	Өрхийн эмнэлэг	Хувийн эмнэлэг	Үйлчилгээ авах шаардлагагүй		
<i>Нас</i>								
20 хүртэл	12.5	0.0	37.5	12.5	25.0	12.5	100.0	8
20-29	9.1	20.5	45.5	6.8	6.8	11.4	100.0	44
30-39	3.7	7.4	66.7	11.1	0.0	11.1	100.0	27
40 ба дээш	16.7	0.0	83.3	0.0	0.0	0.0	100.0	6
<i>Хүйс</i>								
Эрэгтэй	10.0	12.5	47.5	7.5	2.5	20.0	100.0	40
Эмэгтэй	6.7	13.3	60.0	8.9	8.9	2.2	100.0	45
<i>Боловсролын түвшин</i>								
Боловсролгүй/бага	0.0	0.0	100.0	0.0	0.0	0.0	100.0	5
Бүрэн бус дунд	3.2	9.7	67.7	6.5	0.0	12.9	100.0	31
Бүрэн дунд	8.8	23.5	38.2	14.7	5.9	8.8	100.0	34
ТМД/дээд	20.0	0.0	46.7	0.0	20.0	13.3	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>								
Том оврийн тэрэгний жолооч	23.5	11.8	29.4	0.0	5.9	29.4	100.0	17
Зочид буудал, бааранд ажиллагчид	5.3	21.1	52.6	5.3	10.5	5.3	100.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	0.0	14.3	50.0	21.4	0.0	14.3	100.0	14
Саунд ажиллагсад	0.0	0.0	83.3	16.7	0.0	0.0	100.0	6
Баар, цэнгээний газраар үйлчлүүлэгч	9.1	27.3	54.5	0.0	0.0	9.1	100.0	11
Бусад	5.6	0.0	72.2	11.1	11.1	0.0	100.0	18
Дүн	8.2	12.9	54.1	8.2	5.9	10.6	100.0	85

Судалгаанд хамрагдсан БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэлт бүлгийн нийт 85 хүнээс 24 нь буюу 28.2 хувь нь эмнэлгийн шинжилгээ, оношлогоор нотлогдсон суурь өвчтэй гэжээ.

Мөн эмчийн заавар, зөвлөгөөгүй эм, тариа хэрэглэж байсан гэж судалгаанд хамрагдагсадын 70.6 хувь нь хариулсан байна. Энэ нь эмийн зохисгүй хэрэглээ өндөр байгааг нэг талаас илтгэж байна. Судалгаанд БЗДХ/ХДХВ/ДОХ-ын халдвар авах эрсдэл өндөр хэмээн сонгож авсан бүлгийн хүн амын 8.2 хувь (7 хүн) БЗДХ-аар өвчилж байсан гэжээ. Хувь хүний нууцлалыг хөндсөн, нөхөн үржихүйн эрүүл мэндийн эмзэг асуулт байсан тул энэхүү хариултын түвшинд болгоомжтой хандах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, БЗДХ-аар өвчилсөн хүмүүсийн байж болох хамгийн доод түвшин гэж ойлгож болно.

БЗДХ-аар өвчилж байсан 7 хүний 3 нь өвчнөө эдгээхийн тулд эмч, эмнэлэгт хандсан байхад 4 хүн нь өөрөө эмчилсэн байна.

Тэгвэл эрүүл мэндийн үйлчилгээг хэнээс авбал илүүтэйд үздэгийг авч үзвэл (Хүснэгт 5.2.2.8), 76.5 хувь нарийн мэргэжлийн эмчээс, 22.4 хувь нь өрхийн эмчээс, 1.2 хувь нь оточ/бариацаас гэсэн хариултыг өгчээ. Энд боловсролын түвшин дээшлэх тутам нарийн мэргэжлийн эмчээс эрүүл мэндийн үйлчилгээ авах нь илүүтэй гэсэн хариултын хувь нэмэгдэж байна.

Хүснэгт 5.2.2.8 Судалгаанд хамрагдагсад эрүүл мэндийн үйлчилгээг хэнээс авахыг илүүтэйд үзсэн байдал, сонгосон үзүүлэлт, хувь

Сонгосон үзүүлэлтүүд	Эрүүл мэндийн үзлэгийг хаанаас авах нь илүүтэй			Бүгд	Судалгаанд хамрагдсан хүний тоо
	Нарийн мэргэжлийн эмч	Өрхийн эмч	Оточ/бариац		
<i>Нас</i>					
20 хүртэл	75.0	25.0	0.0	100.0	8
20-29	77.3	20.5	2.3	100.0	44
30-39	74.1	25.9	0.0	100.0	27
40 ба дээш	83.3	16.7	0.0	100.0	6
<i>Хүйс</i>					
Эрэгтэй	75.0	22.5	2.5	100.0	40
Эмэгтэй	77.8	22.2	0.0	100.0	45
<i>Гэрлэлтийн байдал</i>					
Огт гэрлээгүй	70.0	27.5	2.5	100.0	40
Гэрлэсэн	84.6	15.4	0.0	100.0	26
Хамтран амьдардаг	83.3	16.7	0.0	100.0	6
Салсан/тусгаарласан/бэлбэсэн.	76.9	23.1	0.0	100.0	13
<i>Боловсролын түвшин</i>					
Боловсролгүй/бага	40.0	60.0	0.0	100.0	5
Бүрэн бус дунд	74.2	25.8	0.0	100.0	31
Бүрэн дунд	76.5	20.6	2.9	100.0	34
ТМД/дээд	93.3	6.7	0.0	100.0	15
<i>Ажил эрхлэлт</i>					
Том оврийн тэрэгний жолооч	76.5	17.6	5.9	100.0	17
Зочид буудал, бааранд аж-чид	78.9	21.1	0.0	100.0	19
Хувиараа алт, жонш олборлогч	78.6	21.4	0.0	100.0	14
Саунд ажиллагсад	66.7	33.3	0.0	100.0	6
Баар, цэнгээний газраар үйл-д	90.9	9.1	0.0	100.0	11
Бусад	66.7	33.3	0.0	100.0	18
Дүн	76.5	22.4	1.2	100.0	85

Судалгаанд хамрагдсан зорилтот бүлгийн хүн амыг ерөнхийд нь дүгнэвэл, бэлгийн эрсдэлтэй зан үйлд хөтлөх архи, тамхины хэрэглээ өндөр, мөн эдгээр хүн амын дийлэнх нь тохиолдлын бэлгийн хавьталд ордог бэлгийн зан үйлтэй байгаа нь БЗДХ/ХДХВ/ДОХ-ын өндөр эрсдэлийг дагуулж байна.

Зорилтот бүлгийн хүн амын ажлын байрны нөхцөл хангалтгүй байгаа бөгөөд зайлшгүй шаардлагатай нөхцлийн талаарх мэдлэг тийм ч сайн биш байна. Зорилтот бүлгийн хүн амын дунд суурь өвчтэй хүн амын эзлэх хувь өндөр байгаа бөгөөд эмчийн зөвлөгөө, зааваргүй өөрсдөө эмчилгээ хийх, эмийн зохисгүй хэрэглээ түгээмэл байна.

Хураангуй

Сумын болон сум дундын эмнэлгийн 10000 хүн амд ногдох их эмчийн тоо сүүлийн 3 жилд тасралтгүй өсч байгаа боловч сум бүрээр ихээхэн ялгаатай байна. 2007 оны байдлаар Баяндалай, Баян-Овоо, Булган, Мандал-Овоо, Сэврэй, Ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Ноён сумдад стандартын доод хэмжээнээс 1-3 сувилагчаар дутуу үйл ажиллагаагаа явуулж байна.

1000 хүн амд ногдох хөгжлийн бэрхиээлтэй иргэдийн тоо Гурвантэс (33.1), Манлай (27.9) сумдад олон, Баян-овоо суманд хамгийн цөөн байна. Сумдын хэмжээнд 1000 хүн тутмаас хэдэн хүн архи, тамхи хэрэглэдгийг авч үзэхэд Цогтцэций, Хүрмэн, Гурвантэс сумдад хамгийн өндөр үзүүлэлттэй байна. 10000 хүн амд бүртгэгдсэн өвчлөлийг 2007 оны байдлаар авч үзвэл Баяндалай, Гурвантэс, Мандал-Овоо, Сэврэй, Хүрмэн, Цогтцэций, Ноён сумдад өндөр хэмжээнд байна. 2005, 2006 онуудтай харьцуулахад 2007 онд бүртгэгдсэн өвчлөл аймгийн хэмжээгээр 82-81 хувиар нэмэгджээ. Өмнөговь аймгийн хэмжээнд сүүлийн 3 жилд бэлгийн замын халдварт өвчиний гаралт өсч, үүний дотор тэмбүү 3.6, заг, хүйтэн 0.6, трихомоноз 0.2 пунктээр тус тус нэмэгджээ.

Бэлгийн замын өвчний эрсдэлтэй бүлгийн хүн амын дотор суурь өвчтэй, архи, тамхи хэрэглэдэг, тохиолдлын бэлгийн хавьталд ордог хүмүүсийн хувь харьцангуй өндөр байгаа нь БЗДХ/ХДХВ/ДОХ-ын өндөр эрсдэлийг дагуулж байна. Зорилтот бүлгийн хүн амын ажлын байрны нөхцөл хангалтгүй байгаа бөгөөд зайлшгүй шаардлагатай нөхцлийн талаарх мэдлэг тийм ч сайн биш байна. Эмчийн зөвлөгөө, зааваргүй өөрсдөө эмчилгээ хийх, эмийн зохисгүй хэрэглээ түгээмэл байна.